

## Ар хорчины уртын дууны утга зүйн судалгааны асуудалд ("Төрт дөрвөн дуу"-ны жишээгээр)

Цэрэнгийн Чулуунцэцэг ✉ 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ [chuka0588@gmail.com](mailto:chuka0588@gmail.com)

Э.Цэлмэг

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь Ар хорчины уртын дууны утга зүйн шинжилгээ хийхэд чиглэгдсэн бөгөөд шинэ гэр бүлийн хуримын ёслолд дуулагддаг "Төрийн дөрвөн дуу"-г жишээ болгон сонгож, хуримын ёс заншил дахь байр суурь, бэлгэдэл, дуулалтын дэс дараалал, дуучдын үүргийг нягтлан судлав. Судалгаанд нийгэм-соёлын контекстийн болон семиотик утга зүйн шинжилгээний арга, перформатив онолыг хослуулан ашиглан Ар хорчин уртын дуу дуулах уламжлалыг өргөн хүрээнд авч үзэв. Эдгээр арга зүйг хослуулан ашигласнаар уртын дуу нь зөвхөн аялгуу, текст, техникээр хязгаарлагдахгүй, харин тухайн дууг төрүүлсэн нийгэм соёлын орчин, зан үйл, хүмүүний сэтгэлгээ, нийгэм-соёлын харилцааны олон талт холбоог багтаасан иж бүрэн соёлын үзэгдэл болох нь тогтоогдов.

Судалгааны үр дүнгээс үзэхэд, Ар хорчины уртын дуу нь зөвхөн уран сайхны илэрхийлэл төдийгүй гэр бүлийн тогтвортой байдал, ёс заншлыг уламжлуулах нийгэм, соёлын чухал механизм болох нь илэрхий байна. Ялангуяа дуучдын харилцан дуулах, үг ба аялгууны давталт нь утга агуулгыг гүнзгийрүүлж, хамтын ой санамжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

**Түлхүүр үгс:** *ёс заншил, перформатив утга зүй, нийгэм-соёлын шинжилгээ, хурим найр, уртын дууны уламжлал, нийгэм-соёлын харилцаа*

## Semantic study of Ar khorchin long songs (A Case study of the “Turiin durvun duu”)

Chuluuntsetseg Tseren ✉ 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
✉ chuka0588@gmail.com

Qilemuge

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** This study conducts an in-depth semantic analysis of Ar Khorchin long songs, focusing on the “Four State Songs” traditionally performed at new family wedding ceremonies. It examines the songs’ role, symbolism, sequence of performance, and the responsibilities of the singers within wedding customs. By combining sociocultural contextual analysis with semiotic and performative theories, the research offers a broad perspective on the tradition of Ar Khorchin long song singing. This methodological approach highlights how the meanings embedded in the songs are expressed within their social and cultural environment by analyzing rituals, performance practices, and semantic content. The findings provide a basis for identifying effective strategies to preserve and promote the cultural heritage of Ar Khorchin long songs.

**Keywords:** *customs, performative semantics, sociocultural analysis, wedding ceremony, long song tradition, social relations*

### Оршил

Монгол уртын дуу нь түүх, ахуй, ёс заншлын гүн утга агуулсан ардын урлагийн өв билээ. Түүний өвөрмөц онцлог нь аялгууны урт, амьсгалын уян хатан байдал, хоолойн өнгөний гүн гүнзгий илэрхийлэлд оршдог бөгөөд энэ нь монголчуудын сэтгэлгээ, байгалийн орон зайтай нягт холбоотой. Монгол угсаатны олон уртын дууны салбарын нэг болох Ар хорчины уртын дуу нь өвөр монголын Ар хорчин хошууны нутгаас гаралтай бөгөөд орон нутгийн соёл, түүх, ёс заншлыг гүнзгий тусгасан өвөрмөц бүтээлүүдээр баялаг юм.

Монгол уртын дууны судалгаанд ерөнхий хэв шинж, уран сайхны онцлог, түүхэн хөгжилд чиглэсэн судалгаа харьцангуй элбэг байдаг боловч Ар хорчины уртын дуу, тэр дундаа хуримын ёслолын хүрээнд дуулагддаг уртын дууны утга зүйн судалгаа харьцангуй хомс байна. Зарим судлаачид хуримын дууны ёс заншлын үүрэг, дуулах дэс дараалалд анхаарсан боловч үг ба аялгууны давталтаар дамжих утга зүйн гүн бүтэц, нийгэм-соёлын харилцааг тусгайлан задлан шинжилсэн судалгаа ховор байна. Иймд энэхүү судалгаа нь Ар хорчины уртын дуу хуримын ёслолын хүрээнд утга зүйн үүднээс авч үзсэнээр судалгааны орон зайг нөхөж буйгаараа онцлог юм.

Ар хорчины уртын дуу нь олон үеийн турш дамжин өвлөгдөж, хурим найр, тайлга тахилга зэрэг ёслолын арга хэмжээнд зайлшгүй дуулагддаг бөгөөд нутгийн

ард түмний оюун санаа, сэтгэл хөдлөлийг төлөөлөн харуулсан “Төрт дөрвөн дуу” зэрэг онцгой дуутай. Эдгээр дуу нь аялгуу, үг, утга зүйн хувьд бэлгэ тэмдэг, ёс заншлын уламжлалтай уялдан хөгжсөн нь түүх, соёлын үнэт өвийг илэрхийлэх гол эх сурвалж юм.

Тиймээс энэхүү судалгааны өгүүлэлд Ар хорчины уртын дууны утга зүйн асуудлыг “Төрт дөрвөн дуу”-ны жишээгээр авч үзэж, эдгээр дууны үгийн утга, бэлгэ тэмдэг, ёс заншлын харилцан уялдааг гүнзгийрүүлэн судлахыг чухалчлав.

Энэхүү судалгааны гол зорилго нь Ар хорчины “Төрийн дөрвөн дуу” хэмээх уртын дууны утга зүйд шинжилгээ хийж, тухайн дууны бэлгэдэл, ёс заншлын гүн давхаргыг тодорхойлон, Ар хорчины уртын дууны өв соёлыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх арга замыг эрэлхийлэхэд оршино.

Энэхүү зорилгын хүрээнд “Төрт дөрвөн дуу”-ны үг, аялгуу, бүтцийн онцлогийг утга зүйн үүднээс задлан шинжлэх; Дуучдын хоорондын харилцан дуулах үйл явц, үг ба аялгууны давталтын утга, үүргийг тодруулах; Уртын дуу нь хуримын ёслол дахь нийгэм-соёлын үүргийг хэрхэн гүйцэтгэж байгааг илрүүлэх; Ар хорчины уртын дуугаар дамжуулан ёс заншил, гэр бүлийн үнэт зүйлсийг шинэ үед хэрхэн өвлүүлж байгааг судлах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн шийдвэрлэсэн болно.

### Судалгааны арга зүй

Уртын дуу нь зөвхөн дууны текст, аялгуу, дуулахуйн техникээр хязгаарлагдахгүй, харин уг дууг төрүүлсэн нийгмийн бүтэц, зан үйлийн орчин, ахуй соёлын нийтлэг шинжүүдийн илрэл байдаг. Тиймээс Ар хорчин уртын дуу, ялангуяа “Төрт дөрвөн дуу”-ны утга зүйн судалгаанд нийгэм-соёлын контекстийн шинжилгээний арга, семиотик, перформатив утга зүйн онолуудыг хослуулан хэрэглэв. Уртын дуу нь зөвхөн текстийн агуулга төдийгүй дуулах арга барил, хоолойн өнгө, үгийн давталт, аялгууны бүтцээр дамжуулан монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээ, ёс заншил, түүхийн мэдрэмжийг илэрхийлдэг.

1. Семиотикийн үүднээс авч үзвэл: Уртын дууны үг болон аялгуу нь тэмдэгшил (signifier) ба тэмдэглэгдсэн (signified) утга хоёрыг хамтатган авч үздэг. Ялангуяа “Төрт дөрвөн дуу”-ны жишээн дээр тухай тухайн дууны үг, аялгуу нь тухайн ёслол болж буй цаг үе, үндэстэн угсаатны ёс заншил, бэлгэдэлтэй уялдан утга давхацдаг (Saussure 1983).
2. Перформатив утга зүй: Ар хорчин уртын дуу дуулах үйл явц нь тухайн дууг гүйцэтгэгчийн оролцоо, сэтгэл хөдлөл, хуримд оролцогчдын харилцааны хүрээнд утга шинээр бий болдог. Энэ тохиолдолд перформанс гэдгийг зөвхөн дуулах биш, тухайн дуугаар дамжуулан ёс заншил, харилцаа, түүхийг амьдралд дахин бүтээх үйл ажиллагаа гэж ойлгож болно (Hymes 1972).
3. Утга, бэлгэ тэмдэг ба уламжлалт соёлын түүх: “Төрт дөрвөн дуу” нь зөвхөн аялгуу төдийгүй тухайн нутгийн соёл, түүхэн үйл явдлыг дүрслэн бэлгэдсэн бүтээл бөгөөд дуучны хувьд тухайн дууг дуулж байхдаа тухайн утга, бэлгэдэлт сэтгэлгээний гүн гүнзгий ойлголттой байх шаардлагатай (Denzin 2018).

## Судалгааны үр дүн

### 1. “Төрт дөрвөн дуу”-ны хурим найрын ёс заншил дахь үүрэг, дуулах дэс дараалал, дуучдын үүрэг ба дүрмийн утга зүйн шинжилгээ

Монгол угсаатны уламжлалт ёс заншил, түүх соёлын салшгүй хэсэг болсон хурим найр нь зөвхөн гэрлэлтийн баяр ёслол төдийгүй нийгэм, угсаатны харилцааг баталгаажуулдаг чухал ёслол билээ. Тийм ч учраас монголчууд залуу хосын гэрлэх ёслолыг “Үр Төрийн хэрэг” хэмээн чухалчлан үзсээр ирсэн.

Монголчуудын дунд “Найрт гурван дуутай, Наадамд гурван даваатай” гэдэг хэлц бий боловч Ар хорчинчууд хуримд “Төрт дөрвөн дуу” дуулах ёс заншилтай байдгаараа бусад хошуу нутгаас ялгаатай. Энэ нь Ар хорчинчуудын эрт дээр үеэс уламжлан ирсэн ёс журам билээ. “Төрт дөрвөн дуу” нэртэй өвөрмөц уртын дуунууд нь шинэ гэр бүлийг үүсгэх, гэр бүлийн ёс заншлыг бэхжүүлэх утга агуулгатайгаар дуулагддаг онцлогтой. Түүнчлэн, хурим найрын үеийн дуулах дэс дараалал, дуучдын хүүгийн болон охины талын үүрэг гүйцэтгэх дүрэм журам нь соёлын гүн гүнзгий утга агуулгатай.

Бид энэхүү судалгаагаар “Төрт дөрвөн дуу”-ны хурим найрын ёс заншил дахь үүрэг, дуулах арга барил, дэс дараалал, дуучдын үүрэг болон дуулах дүрэм, журам дахь утга зүйн гүн гүнзгий шинжилгээг хийв. Энэ нь монголын уртын дууны уламжлалт ёс заншил, утга зүйн онцлогийг ойлгож, хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

#### *Хурим найрын ёс заншил дахь “Төрт дөрвөн дуу”-ны үүрэг*

Хурим найр нь шинэ гэр бүл үүсгэх, үр удам залгах, хоёр овог аймгийн холбоо батжих гүн утга агуулсан нийгэм соёлын арга хэмжээ юм. Иймээс “Төрт дөрвөн дуу” нь энэхүү ёслолыг утга төгөлдөр болгох дараах гол үүргүүдийг гүйцэтгэнэ.

- *Гэр бүлийн ёс заншлыг илэрхийлэх:* Тэдгээр дуу нь гэр бүлийн үнэ цэн, хүний ёс суртахуун, хүндлэл, хайр сэтгэл зэрэг зан үйл, харилцааны дүрмийг бэлгэддэг.
- *Ёслолын уур амьсгалыг бий болгох:* Хуримын сэтгэл хөдлөл, ариун ёс, баярын уур амьсгалыг хөгжмийн аялгуу, дуулах хэлбэрээр илэрхийлдэг.
- *Орон нутгийн зан үйл, уламжлалыг хадгалах:* Дууны үг, аялгуу нь тухайн нутгийн өвөрмөц зан үйл, сэтгэлгээ, хэл хэллэг, бэлгэдлийг дамжуулдаг.

Ар хорчин уртын дууны “Төрт дөрвөн дуу” нь шинэ гэр бүл болоход зайлшгүй дуулдаг уламжлалт дуунууд бөгөөд хурим найрын ёслолд гүн гүнзгий утга агуулга, зан үйл, ёс суртахуун, нийгмийн харилцааг илэрхийлэх үүрэгтэй. Энэ дөрвөн дуу нь хуримын үе шат бүрт дуулагдаж, шинэ амьдралын эхлэлд хувь хүнд болон гэр бүлд амар амгалан, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөх зан үйл болон оролцдог. Жишээ нь, “Намаг цээлийн бургас” дуу нь охин дүүгээ харь урагт мордуулсан төрсөн ахын сэтгэлийг илэрхийлсэн бөгөөд гэр бүлийн үүрэг хариуцлага, ах дүүсийн хайр, халамжийн мөнхийн утгыг илтгэдэг. Энэхүү дуу нь дөрөв, зургаа, найм зэрэг тэгш тоотой холбоотой зан үйлтэй уялдан, монгол угсаатны тооны бэлгэ тэмдгийг илэрхийлдэг нь соёлын гүн гүнзгий ухагдахууныг илтгэнэ (Дулам 2011).

Хурим найрт “Төрт дөрвөн дуу”-г дуулах нь зөвхөн дуу хөгжим төдийгүй ёс заншлын хөтөч, ёслолын үндсэн бүрэлдэхүүн хэсэг билээ. Залуу хосуудын талууд ээлжилсэн дуулалт нь тухайн гэр бүлийн харилцаа, эрдэм боловсрол, ёс суртахууны

үнэт зүйлсийг шингээсэн уламжлалт тогтолцоог бэхжүүлдэг. Энэ нь тухайн хосын ирээдүйн амьдралд амар амгалан, аз жаргал, үр хүүхдийн сайн сайхныг хүсэн ерөөж, нийгмийн харилцааны эрүүл, зөв хөгжлийг бэлгэддэг (Гэрэлбат 2019).

### ***“Төрт дөрвөн дуу”-ны дуулах дэс дараалал ба дуучдын үүрэг***

Ар хорчин хурим найрын ёслолд “Төрт дөрвөн дуу”-г тодорхой дэс дараалал, дүрэм журмын дагуу дуулдаг бөгөөд энэ нь ёслолын гүн утга агуулга, үргэлжилсэн уламжлалыг хадгалах гол үндэс болдог (Оюунгэрэл 2016, 135).

#### ***Дэс дараалал:***

- Эхний дуучин нь гэр бүлийн ахмад насны төлөөлөл, ураг төрөлдөө хүндлэгдсэн эрхэм хүмүүн байх бөгөөд хуримын эхний дууг дуулж, ёслолыг нээдэг. Энэ нь ёслолын нэгдсэн эхлэл бөгөөд бүх оролцогчдыг ёс заншлын хүрээнд нэгтгэдэг.
- Хүүгийн талын залуучууд дараагийн дугаарт дуулах ба тэдний үүрэг нь шинэ гэр бүлийн эхлэл, эрч хүч, бат бэх зан чанарыг илэрхийлж, дууны хүч чадал, эр зориг, эр хүний үүрэг, хариуцлагыг илэрхийлнэ.
- Харин хүүхний талын дуучид дараагийн дууг дуулж, шинэ эхнэрийн ариун гэгээн нууцлаг, эмзэг сэтгэл, гэр бүлийн халамж, тайван амгалан байдлыг илтгэдэг дуунуудыг дуулна.
- Эцэст нь ахмад дуучид дахин оролцож, ёслолын дээд түвшний ерөөл, ёс суртахууны захиасуудыг дамжуулна.

Ийнхүү дуучид “Төрт дөрвөн дуу”-г эхнээс төгсгөлийн дагуу дуулах бөгөөд дуунууд нь байгалийн орон зай, хүний сэтгэлийн өөрчлөлттэй зохицсон аялгуу, үгийн агуулгатайгаар ээлжилнэ. Энэхүү дэс дараалал нь хуримын ёслолын бүрэн бүтэн байдлыг хадгалах төдийгүй дуучдын хоорондын харилцан хүндлэл, харилцан үйлчлэлийг илэрхийлдэг.

#### ***Дуучдын үүрэг:***

- Дуучид нь дуулах ур чадвар, хоолойн техникээс гадна ёс заншил, уламжлалыг мэддэг байх шаардлагатай.
- Тэдгээрийн хоолой, хувцаслалт, зан араншин нь хуримын ёслолд тохирсон, нийгмийн хариуцлагын үүрэг гүйцэтгэнэ.
- Дуучдын хоорондын харилцан уялдаа, дууны шивнээ, хариу дуу гэх мэт нарийн дүрмүүд нь ёслолын амжилттай явагдах үндэс болдог.
- Хоёр талын дуучид ээлжлэн дуулахдаа тухайн дууны агуулга, утга санааг гүнзгий мэдэрч, дамжуулах үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү дэс дараалал ба дуучдын үүрэг нь хуримын ёслолын бүтцэд зохион байгуулалт, уялдаа холбоог бий болгож, уламжлалт үнэт зүйлсийг залгамжлан дамжуулах соёлын гол хэлбэр болдог.

### ***“Төрт дөрвөн дуу”-ны утга зүйн шинжилгээ***

“Төрт дөрвөн дуу” нь хурим найрын ёслолд дуулагддаг учраас утга агуулга нь гэр бүл, нийгэм, ёс заншлын бэлгэдэл, ёс суртахууны сургамжийг агуулсан байдаг. Утга зүйн талаас дараах үндсэн асуудлуудыг авч үзэж болно.

#### ***Ёс заншлын ба нийгмийн утга:***

- Дууны үгс нь гэр бүлийн шинэ холбоог бататгаж, хосуудын харилцаа, эв найрамдлыг бэлгэддэг.

- Хурим найрын бэлгэдэл, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, нийгмийн харилцааны зарчмыг дамжуулдаг.
- Тухайн дууны аялгуу, хэлц үг, зан үйлтэй холбогдсон утга санаа нь тухайн нийгмийн ёс суртахууны системтэй уялддаг.

***Тэмдэглэгээ, бэлгэдлийн утга:***

“Төрт дөрвөн дуу”-ны дуулалтын үеийн дүрэм, журам нь утга зүйн талаас олон түвшний утга агуулдаг. Жишээлбэл,

- дуучдын тоо нь 4, 6, 8 зэрэг тэгш тоонд байх ёстой (Эрдэнэ 2022, 40) нь монгол уламжлалт бэлгэдлийн хүрээнд гэр бүлийн тогтвортой байдлыг илтгэдэг.
- Дууны нэр, үгэнд агуулсан байгаль, амьтан, гэр бүл, ураг садан гэх мэт сэдвүүд нь бэлгэдэл болон домогт утгатай. Жишээ нь, “Намаг цээлийн бургас” дуу нь ахын сэтгэлийг төлөөлж, ургийн холбоо, гэр бүлийн үнэт зүйлсийг илэрхийлдэг.

***Амьсгаа, хоолойн өнгө, аялгууны утга:***

- Дуучдын хоолойн өнгө нь тухайн дууны сэтгэл хөдлөл, ёс заншлын агуулгыг улам тодруулж өгдөг.
- Амьсгалын тогтвортой байдал, цэвэр хоолой нь сэтгэлийн ариун байдлыг илэрхийлэх бөгөөд дууны өнгө, аялгуу нь хүний дотоод сэтгэл, ёс зүйтэй холбоотой.
- Цээл хоолойн дуулалт нь далд утга агуулгыг илэрхийлэхэд ашиглагддаг.
- Аялгууны өөрчлөлт, үсрэлтүүд нь дуучдын мэдрэмж, ёс суртахууны захиасыг хүргэдэг.

***Утга зүйн давтамж ба нийгмийн үүрэг:***

- “Төрт дөрвөн дуу” нь тухайн орон нутгийн ёс заншлыг хадгалах, дамжуулах үүрэгтэй.
- Дуучдын хоорондох харилцан дуулах, үг, аялгууны давталт нь утга агуулгын гүнзгийрлийг бий болгодог. Ингэснээр гэр бүлийн бат бөх байдлыг хангаж, шинэ үеийнхэнд ёс заншлыг уламжлуулдаг.

Хүүгийн болон охины дуулалтын ялгаа: Хүүгийн талынхны дуулалт нь хүч чадал, бат бэх байдал, үр удам, хамгаалалтыг илэрхийлдэг бол охины талынхны дуулалт нь хайр, халамж, эмзэглэл, гэр бүлийн амар амгаланг илэрхийлнэ.

Үгийн агуулга ба зан үйл: Дууны үгс нь ёс суртахууны сургамж, угсаатны зан заншил, эртний домог түүхийг дамжуулдаг тул хуримын ёслолын үеийн зан үйл, хэм хэмжээнд зайлшгүй нийцсэн байх шаардлагатай.

Энэ бүхнээс үүдэн “Төрт дөрвөн дуу” нь монголын уртын дууны онцлог, ёс заншлын утга зүйн томоохон хэлхээ бөгөөд хурим найр зэрэг үндэсний зан үйлд зайлшгүй хэрэгцээтэйгээр дуулагддаг соёлын агуулгаар баялаг өв юм. Түүнчлэн, хуримын үеийн дуулах дэс дараалал, дуучдын үүрэг, дуулах дүрэм нь утга зүйн гүн гүнзгий мөн чанарыг агуулсан бөгөөд үүнийг судлах нь Монгол угсаатны соёлын хадгалалт, өвлүүлэлтэд чухал хувь нэмэр оруулна хэмээн үзэв.

***Нийгэм-соёлын контекст ба “Төрт дөрвөн дуу”-ны үүрэг***

Монгол угсаатны уламжлалт ёс заншилд байдаг “насны гурван найр”-ын нэг нь гэрлэх ёслолын хурим найр юм. Тэрхүү баярт үйл явдлын нэгэн гол онцлог нь

“Төрт дөрвөн дуу” гэсэн өвөрмөц багц дуу байдаг бөгөөд эдгээр дуу нь шинээр гэр бүл зохиож буй залуусын амьдралын эхлэл, угсаа, ёс суртахуун, харилцааны үнэт зүйлсийг бэлгэдэн илэрхийлдэг.

“Төрт дөрвөн дуу” нь хуримын ёслолд тус тусын онцлог үүрэгтэйгээр дуулагдаж, тусгай дэс дараалал, дуучдын хуваарилалттайгаар залуу хосын хувь заяа, гэр бүлийн аз жаргал, амар амгаланг бэлгэддэг соёлын цогц илэрхийлэл билээ. Энэ нь Монгол нүүдэлчин ахуйд уламжлал, ёс суртахуун, ард түмний оюун санааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Дуучдын үүрэг нь зөвхөн дуулах төдийгүй ёс заншлыг дамжуулах, залууст зааж ойлгуулах, нийгмийн харилцааны дүрэм журмыг илэрхийлэх амьд хэлбэр болдог. Тиймээс хурим найрын дуулах дэс дараалал нь зөвхөн урлагийн ур чадвар төдийгүй ёс заншлыг чандлан сахиулах ёстой нэгэн практик үйл ажиллагаа юм.

## 2. “Төрт дөрвөн дуу”-ны хурим найр дахь үүрэг, дуулах дараалал, утга зүйн шинжилгээ

### Хүснэгт 1

Дараалал	Дууны нэр	Дуулах тал	Ёслол дахь үүрэг	Уг, утгын гол санаа	Утга зүйн онцлог болон тэмдэглэл	Дуучдын үүрэг ба онцлог
I	Богд Чингис	Хүндэт ахмад тэргүүлж, 2 тал хамтдаа дуулна.	Хурим найрын эхэнд дуулна. Язгуур угсаа, хүч чадлыг бэлгэднэ.	Монголын язгуур угсаа, төрийн эрх мэдлийн бэлгэдэл, хүч чадал, эв нэгдэл	Хүчирхэг эгшиг, гүн утга агуулсан, түүхэн дурсамжтай дуу	Хоёр талын дуучид хамтдаа дуулж, хуримын ёс заншлыг эхлүүлнэ.
II	Цацран гийгүүлнэ	2 тал хамтдаа дуулна.	Шинэ гэр бүлийн гэрэл гэгээ, амар амгаланг илэрхийлнэ.	Ирээдүйн гэрэл гэгээ, аз жаргал, амар амгалангийн бэлгэдэл	Гэрэл гэгээтэй, тайван эгшиг, гэр бүлийн аз жаргалыг илэрхийлнэ.	Дуучид ээлжлэн дуулах бөгөөд харилцан үүрэгтэй.
III	Ургамал цэцэг	Хүүгийн тал	Өсөлт, үржил шим, хайр халамжийг бэлгэднэ.	Гэр бүлийн бат бөх холбоо, хайр халамж, баялаг амьдрал	Хайр сэтгэлийн илэрхийлэл давамгайлсан зөөлөн эгшиг	Эмэгтэй дуучин гол үүрэг гүйцэтгэж, сэтгэл хөдлөлийг илэрхийлнэ.
IV	Намаг цээлийн бургас	Хүүхний тал	Ах дүүгийн сэтгэл, гэр бүлийн уламжлал, үр хойчийг бэлгэднэ.	Ах дүүгийн хайр, хамтын хичээл зүтгэл, гэр бүл уламжлалын үнэ цэн	Ёс заншлын бэлгэдэл бүхий дунд зэрэг хатуу эгшигтэй.	Хүүгийн талын дуучин гол үүрэгтэй, найрыг жаргаах үүрэгтэй.

1. Дуулах дараалал: Хурим найрын ёслолын дагуу “Богд Чингис” дуугаар эхэлж, “Намаг цээлийн бургас” дуугаар өндөрлөнө. Энэ дараалал нь ёс заншил, утга агуулгын хувьд логик уялдаа бүхий уламжлал юм.
2. Дуулах тал: Зарим дууг хамтаар буюу хоёр тал дуулдаг бол, зарим нь зөвхөн эмэгтэй, эсвэл зөвхөн хүүгийн тал дуулна. Энэ нь тухайн дуунд холбогдох утга, ёс заншлын онцлогоос шалтгаалдаг.
3. Дуучдын үүрэг: Ёслолд дуучдын үүрэг нь зөвхөн дуулах биш, ёслолын утга, дууны бэлгэ тэмдэг, дуулалтын хэв маягийг чанд баримтлахад оршино. Тухайлбал, “Богд Чингис” дууг хоёр талын дуучид хамтдаа дуулж, хүч чадал, эв нэгдлийг бэлгэддэг бол “Ургамал цэцэг” дууг эмэгтэй тал голлон дуулдаг.
4. Утга зүйн онцлог: “Төрт дөрвөн дуу”-ны үг нь бэлгэдэл, домог, түүхэн үйл явдал, ёс заншил, гэр бүлийн харилцаа зэрэг олон давхар утга агуулдаг. Дуу бүрийн аялгуу, үгийн утга нь тухайн хурим найр, гэр бүлийн ёслолын өөр өөр үе шат, утга санаатай уялдаж байдаг.

### Хэлэлцүүлэг

Энэхүү өгүүлэлд угсаатны хөгжим судлалын хүрээнд уртын дууны үг, аялгуугаар илэрхийлэгдэж буй утга агуулыг тодорхой нэгэн дууны жишээгээр судлан тайлбарлахдаа судалгааны онол арга зүйн асуудлыг илүү анхаарч үзсэн болно.

Судалгаанд перформатив онолын чиг хандлагыг баримтлан нийгэм-соёлын контекстийн болон семиотик утга зүйн шинжилгээний аргыг хослуулан ашигласнаар “Уртын дуу нь зөвхөн үг, аялгуу, дуулах техникээр хязгаарлагдахгүй, харин тухайн дууг төрүүлсэн социокультур орчин, зан үйл, хүний сэтгэлгээ, нийгмийн харилцааны олон талт холбоог багтаасан иж бүрэн соёлын үзэгдэл болохыг тогтоох бололцоотой хэмээн үзэв.

Ж.Бадраа “...монгол ардын дууны дотроос уртын дуу бол охь дээж нь мөн бөгөөд манай ардын дууны уран бүтээлийн сонгодог хэлбэр мөн...” гээд уртын дууны утга агуулгын талаар “... гоо зүйн ухамсраас гадна улс төр, ёс суртахуун, хууль ёс (хэв журам), шашин шүтлэг, гүн ухаан, шинжлэх ухаан зэрэг нийгмийн ухамсрын гол гол хэлбэр нэгдмэл цогц байдлаар хадгалагдсан байдаг...” (Бадраа 2017, 124-132) гэсэн нь Ар хорчин нутгийн “Төрт дөрвөн дуу”-нд хийсэн утга агуулгын шинжилгээний үр дүнтэй яв цав таарч байгаа нь бидний энэ удаагийн судалгаанд хэрэглэсэн арга зүй оновчтой болохыг харуулж байна. Түүнчлэн, уртын дуу нь зөвхөн аялгуу, дуу төдийгүй хуримын зан үйлийн “хууль”-чилсан бүтцийн элемент болохын хувьд социокультур контекстээрээ илүү өвөрмөц болох нь ч харагдаж байна. Тухайлбал, энэ удаагийн судалгааны дашрамд Х.Гэрэлбатын тэмдэглэсэн Ар хорчин дууны “намба төрх” (Гэрэлбат 2019) ч семиотик утга зүйн үүднээс гүнзгий тайлбарлагдлаа.

Ар хорчин нутгийн ахмад дуучдын дуулах арга барил, зан үйлийн дарааллыг бодит жишээ (Төрт дөрвөн дууны дэс дараалал)-тэй тулган үзвэл, энэхүү “амьд” гүйцэтгэл нь зөвхөн дуу дуулах бус, төрт ёс, гэр бүлийн харилцааг бэхжүүлдэг нийгмийн үйлдэл болохыг бидний шинжилгээний үр дүн илтгэн харууллаа.

Өмнөх судалгаанууд ихэвчлэн дууны аялгуу, хөг эгшигт анхаардаг байсан бол энэхүү судалгааны шинэлэг тал нь “Утга-Зан үйл-Нийгэм” гэсэн гурвалсан холбоонд Ар хорчин уртын дууг социокультур болон семиотик талаас нь нэгтгэн шинжилсэн анхны оролдлого байсанд оршино.

Цаашид, орчин үеийн утга зүйн бусад онол, арга зүйг хэрэглэн дуулах үйл явц, ёс заншлын утга учрыг нэгтгэн гүнзгийрүүлсэн судалгаа хийж хэлэлцүүлэх нь уртын дууны өвийн хадгалалт хамгаалалт, өвлүүлэн уламжлуулах гэх мэт олон талт үйл ажиллагаанд үр дүнгээ өгөх өндөр ач холбогдолтой.

### Дүгнэлт

Энэхүү судалгааны хүрээнд Ар хорчины уртын дууны утга зүйн судалгааг “Төрт дөрвөн дуу”-ны жишээн дээр хийж, уг дууны Ар хорчин нутгийн ёс заншил дахь үүрэг, бэлгэдэл, дуулах дэс дараалал болон дуучдын нийгэм соёлын үүргийг нарийвчлан шинжиллээ. Уртын дуу нь зөвхөн аялгуу, текст, техникээр хязгаарлагдахгүй, харин тухайн дууг төрүүлсэн нийгэм соёлын орчин, зан үйл, хүний сэтгэлгээ, нийгмийн харилцааны олон талт холбоог багтаасан иж бүрэн соёлын үзэгдэл болохыг тогтоолоо.

Перформатив онолыг баримтлан утга зүйн шинжилгээ хийснээр дуучдын дуулах үйл явц нь нийгмийн ёс заншил, үнэт зүйлсийг бататган илэрхийлэх, амьдралын онцлогтой уялдах идэвхтэй үйлдэл болохыг онцлов. Мөн “Төрт дөрвөн дуу”-ны хурим найрын дэс дараалал, эрэгтэй, эмэгтэй дуучдын үүрэг нь гэр бүл, нийгмийн эв нэгдлийг бэлгэдсэн ёс заншлын бүтэцтэй холбоотой гэж үзэв. Энэ нь уртын дууг зөвхөн урлаг төдийгүй нийгмийн харилцааны идэвхтэй хөшүүрэг болгон танин мэдэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн Ар хорчин уртын дууны утга зүйн судалгаа нь Монгол угсаатны өв соёлыг хадгалан хамгаалах, уламжлалт дуулалтын арга барилыг үеэс үед дамжуулан уламжлуулах суурь болохоос гадна орчин цагийн соёл, боловсролын үйл ажиллагаанд ашиглах арга зүйн шинэ чиглэлийг тодорхойлж өгөв. Энэ нь ардын урлагийг мэргэжлийн түвшинд судлах, түгээн дэлгэрүүлэх үр дүнтэй үйл ажиллагааны жишиг болох боломжтой юм.

Иймд цаашид Ар хорчины төдийгүй бусад уртын дууны өвийг хадгалах, хамгаалах, судлахдаа нийгэм-соёл болон перформатив, семиотикийн онол, арга зүйг улам бүр хөгжүүлэн, дуулах үйл явц, ёс заншлын утга учрыг нэгтгэн гүнзгийрүүлсэн судалгаа хийх нь зүйтэй гэж үзэж байна.

### Ашигласан материалын жагсаалт

#### **Монгол хэлээр:**

Бадраа, Ж. 2017. *Ардын урлаг судлал*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэлийн газар.

Баянжаргал, С. 2000. *Монгол уртын дууны учир зүй*. Хөх хот: ӨМӨЗО ардын хэвлэлийн хороо.

Гэрэлтү. 2003. *Монгол Уртын дуу жич дуулахуй*. Хөх хот: ӨМАХХ.

Гэрэлбат, Х. 2019. *Ар хорчин уртын дууны өвөрмөц онцлог*. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй I. Тооны бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Битпресс.

Мулаан. 2007. “Уртын дууны нэр томъёо ба тэдгээрийг дүрэмжүүлэх тухай санал.”  
*Монгол үндэстний уртын дууны эрдэм шинжилгээний хурлын өгүүллийн түүвэр*: 638.

Оюунгэрэл, Р. 2016. *Арван сумын хуримын ёс*. Хөх хот: ӨМАХХ.

Хурцаа, Б., Санжээ, Б. 2006. *Ар хорчин хошууны түүхийн сурвалж бичиг 1*. Хөх хот: Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо.

**Гадаад хэлээр:**

Denzin, Norman K., and Yvonna S. Lincoln, eds. 2018. *The SAGE Handbook of Qualitative Research*. 5th ed. Thousand Oaks, CA: SAGE Publications.

Hymes, Dell. 1972. “Models of the Interaction of Language and Social Life.” In *Directions in Sociolinguistics: The Ethnography of Communication*: 35–71, edited by John J. Gumperz and Dell Hymes.

Saussure, Ferdinand de. 1983. *Course in General Linguistics*. Translated by Roy Harris. London: Duckworth.